



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/80

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол хэлний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоол “Үндэсний хөтөлбөр III”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Үндэсний хөтөлбөр III”-ыг иргэдэд таниулах, сумын иргэдэд монгол бичиг сурах боломжийг олгох зорилгоор бүтээгдсэн контент хичээлүүдийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Отгонжаргал (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүд:


Э.Төрмандах (Соёлын төвийн дарга)
Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)
М.Энхжаргал (Нягтлан бодогч)

2. Контент хичээлүүдийг байгууллагын хөрөнгөнд бүртгэн иргэдэд түгээн дэлгэрүүлж, сургалт зохион байгуулахыг Соёлын төвийн дарга (Э.Төрмандах), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Отгонжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ



42121-685